



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/437

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 56 дугаар тогтоолыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системийг нэвтрүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулахад шаардлагатай зардалд 15,000,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээний зардалд зарцуулах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 5.8 дахь Төрийн бүтээмжийг сайжруулах чиглэлийн төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Анхбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 05-ны өдрийн
437 дугаар захирамжийн хавсралт



ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ ЗАРДАЛ

Д/д	Зориулалт	Хэмжих нэгж (л)	Нэг бүрийн үнэ	Дүн
1	Шатахууны зардал (16 суманд)	4333	3,000	13,000,000
2	Дуудлага худалдааны бусад зардал	16	125,000	2,000,000
Нийт дүн				15,000,000

-оОо-